

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн халамжийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1.4-т “Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.”, 3.1.5-д “Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.”, “Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.”, “Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэж тусгасан.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар заасан.

Эдгээр бодлогын зорилттой уялдуулан нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд тооцоо, шинжилгээ хийж, зарим хөтөлбөрийг багасгах, хөдөлмөрлөх чадвартай боловч халамж хүртдэг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэг өрхөд ногдож байгаа халамжийн төрлүүдийг судлан, олон төрөл байгаа тохиолдолд тодорхой хязгаартай болгох, хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгахад анхаарч нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, үйлчилгээг сайжруулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Нийгмийн халамжийн нийт зардлыг огцом бууруулахгүйгээр, халамжийн төсвийн хүрээнд дахин хуваарилалт хийнэ. Нийгмийн халамжийг дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот хэсэгт чиглүүлж, хүүхдийг боловсролд тэгш хамруулахад анхаарч, цаашид үе дамжсан ядуурлаас сэргийлэх бодлого баримтална.

Үндэсний статистикийн хорооны хийсэн судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 1990 онд 36 хувь байсан бол 2022 онд 27.1 хувь болж, 914.2 мянган хүн ядуу амьдарч байна. Монгол Улс нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнд жилд 2.3 их наяд гаруй төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байгаа боловч ядуурал дорвитой буураагүй байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 онд нийт 2.4 их наяд төгрөг зарцуулснаас 1.5 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан байна.¹ Зарцуулсан нийт зардлын 27.8 хувь буюу 673.6 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжид зарцуулжээ.

¹ Нийгмийн халамжийн сангийн 2025 оны жилийн эцсийн тайлан, ХХҮЕГ

Харин 1,745.8 тэрбум төгрөг буюу нийт зардлын 72.2 хувийг 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, одонтой эх, хүүхдийн мөнгө, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг олгож байгаа хөтөлбөрт зарцуулсан.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 2000 онд 1.1, 2019 онд 1.8, 2021 онд 4.5, 2023 онд 3.7, 2024 онд 3.2, 2025 онд 2.7 байна. Харин улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь нь 2000 онд 3.0, 2019 онд 5.8, 2021 онд 12.6, 2023 онд 9.9, 2024 онд 9.1, 2025 онд 10.7 байна.

Хөгжиж буй орнуудын хувьд нийгмийн халамжийн зарцуулалт Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь дунджаар 1.6 хувьтай (ДБ, 2015) байдаг бөгөөд үүнтэй харьцуулахад Монгол Улсын нийгмийн халамжид зарцуулж байгаа зардал харьцангуй өндөр юм.

Одоогийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн зорилго нь ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглээгүй, мөнгөн тэтгэмж давамгайлсан, халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох зарчмыг нэвтрүүлээгүй, халамжийн ба хөдөлмөр эрхлэлтийн бодлого тус тусдаа хэрэгжиж байна. Иймд амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулахгүй олгодог эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн бодлого, төсөв, зарцуулалтыг халамжийн бодлогоос зааглаж, шинээр боловсруулж буй Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэгтгэнэ.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийгмийн халамжийн арга хэмжээ нь нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг, нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн 3 төрөлтэй байхаар тусгасан. Нийгмийн халамжийн тэтгэмжийн төрөл, тэтгэмж тогтоолгох, шийдвэрлэх хугацаа, түүнийг олгохтой холбогдох харилцааг зохицуулна.

Одоогийн Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь амьжиргааны түвшин харгалзахгүй олгогдож байна. Тухайлбал, алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлтийн зардлын 65 хувь нь хамгийн сайн амьжиргаатай 20 хувьд ногдож байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийн зардлын 50-аас дээш хувь нь хамгийн бага амьжиргаатай 40 хувьд хуваарилагдсан байна. Эхчүүдэд олгох тэтгэмжүүд, хүүхдийн мөнгөний нийт зардлын 50 орчим хувь хамгийн амьжиргаа багатай 40 хувьд ногдож байна. Ахмад настанд олгох тэтгэмж, хөнгөлөлт нь илүү амьжиргаа сайтай иргэдэд чиглэж байна.²

Иймээс Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлээр өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулж, тэтгэмжийн хэмжээг ялгаатай тогтоохоор тусгаж байна.

Халамжийн тэтгэмжийн хэмжээг ахмад настанд өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд хүүхдийн тоо, өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан ялгаатай тогтооно.

² Монгол Улсын Нийгмийн халамжийн систем: Зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн төлөв байдал, 2019 он, Эрдэм Партнерс ХХК,

Мөн халамжийн тэтгэмжийн хэмжээ нь ахмад настанд өрхийн амьжиргааны түвшин, ахмад настны цогц үнэлгээ, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа, 18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох халамжийн тэтгэмжийн хэмжээ нь хүүхдийн тооноос хамаарч тус тус ялгаатай байна.

Нэг өрхөд үзүүлэх халамжийн үйлчилгээний давхардлыг арилгах зорилгоор тухайн өрхөд улсын төсвөөс болон нийгмийн халамжийн сангаас сард олгож байгаа халамжийн тэтгэмж, дэмжлэгийн нийлбэр, өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүний тоо зэргээс хамаарч халамжийн тэтгэмжийн хэмжээг бууруулж тооцож болохоор тусгасан.

Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг түүний нөхцөл, шалгуур, хугацаатай холбоотой харилцааг тусгасан. Зорилтот өрхийн хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг халамжийн хөтөлбөрүүдтэй уялдуулах, хүн капиталд хөрөнгө оруулах, үе дамжсан ядуурлаас сэргийлэх бодлого тусгасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:

- ❖ халамж зайлшгүй шаардлагатай амьжиргаа багатай өрхийг зөв тодорхойлох, мэдээллийн санг сайжруулах, салбар дундын уялдааг хангах;
- ❖ хүн амын амьжиргааны түвшин доогуур, эмзэг байдалд өртсөн зорилтот өрх, иргэний амьжиргааг дэмжих;
- ❖ амьжиргаа багатай өрхийн жирэмсэн эх, бага насны хүүхдэд бичил тэжээл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх, тэдгээр өрхийн өрхийн хүүхдийг суралцахад дэмжлэг үзүүлэх;
- ❖ өрх иргэнд кейс менежментийн үйлчилгээнд суурилан нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хэрэгцээнд суурилсан үйлчилгээ үзүүлэх;
- ❖ нийгмийн ажилтны мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх;
- ❖ халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд амьжиргаа багатай өрхийн гишүүдийн чадавхжуулах, бие даан амьдрах урт хугацааны үйлчилгээг шинээр нэвтрүүлж, мэргэжлийн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэх;
- ❖ хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хугацаатай болгох, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүнд олгохыг зогсоох;
- ❖ гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг шинээр нэвтрүүлэх;
- ❖ нийгмийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар өрх, иргэдийг ядуурлаас гаргах, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн хөтөлбөрийг орон нутгийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;
- ❖ нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хугацаатай болгох, халамжийн хөтөлбөрт хамрагдсан бол тодорхой хугацааны дараа хөтөлбөрөөс гардаг, эсхүл эхний хөтөлбөрийн нөхцөлийг хангасан бол дараагийн хөтөлбөрт шилждэг байх;
- ❖ халамжийн үйлчилгээний давхардлыг арилгах;
- ❖ эх, хүүхдэд чиглэсэн үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогоос зааглаж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгах;

- ❖ архинд донтсон иргэний донтолтыг бууруулах нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ, орон гэргүй иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ үзүүлэх;
- ❖ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх үйлчилгээний зардлыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцах;
- ❖ хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлдлийн чадамжаас хамааран тэтгэмжийг нэмэгдүүлэн олгох;
- ❖ хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхцөл байдал, үйлдлийн чадамжид үндэслэн тэдний хэрэгцээнд нийцсэн олон төрлийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг болох;
- ❖ сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн газар асруулж байгаа асруулагчийн зардлыг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд зөвхөн эрүүл мэндийн байгууллага хариуцаж байгаад өөрчлөлт оруулж, сэтгэцийн тусгай төрөлжсөн асрамжийн газар асруулж байгаа асруулагчийн хоол, хувцас, ахуйн хэрэгцээний зардлыг норм, нормативын дагуу нийгмийн халамжийн сангаас зарцуулах;
- ❖ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэхэд үүсдэг олон шат дамжлага, хүнд суртлыг арилгах, эрүүл мэндийн салбартай санхүүжилт, үйл ажиллагааны уялдааг сайжруулан өөрчлөх;
- ❖ нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлох, хяналтыг сайжруулах;
- ❖ нийгмийн халамжийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг асуудлыг тусгасан.

Улс орнуудын нийгмийн халамжийн тогтолцоонд бэлэн мөнгө олгохоос гадна зорилтот бүлгийн өрх иргэдийг сургах, чадавхжуулах, хөгжүүлэх, бие даан амьдрахад нь туслах үйлчилгээ давамгайлдаг. Манай улсын хувьд бэлэн мөнгөний хөтөлбөрүүд нийт халамжийн сангийн зардлын 90.0 гаруй хувийг эзэлж байна. Харин хувийн хэвшил, мэргэжлийн ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж байгаа асаргааны үйлчилгээ болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд 0.3 хүрэхгүй хувийг л зарцуулж байна.

Нийгмийн халамжийн одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн зан үйл, хандлагыг өөрчлөх, кейс менежментэд суурилсан үйлчилгээ нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулж тэдний амьжиргааг дэмжих, ажлын байртай болгох, улмаар ядуурлаас аажмаар гарган бие даан амьдруулахад чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ дутмаг байна.

Мөн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу өрх, тэдний хүүхдүүд, хөдөлмөрийн чадваргүй гишүүн, орон гэргүй өрх, иргэн зэрэг төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүн амын онцлог бүлэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, зуд зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэж малчид амьжиргааны эх үүсвэрээ алдаж, ядуу өрхийн тоонд орж байгааг анхаарч, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэн үзүүлэх, энэ чиглэлд халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хүргэх бодлогын шинэчлэл хийх шаардлагатай байна.

Зорилтот өрхийг зөв тодорхойлох өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг боловсронгуй болгох, төрийн мэдээллийн систем, их өгөгдөлд суурилсан үнэн зөв тодорхойлон, түүнийг салбар дундын бодлого хөтөлбөрт ашиглах нь ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд хамгийн чухал байгаа тул төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээний төрлүүдийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцлах, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн амьжиргааг сайжруулах, бие даан амьдрахыг дэмжихэд чиглэсэн шинэ үйлчилгээ бий болгох нь ядуурал буурахад эерэг нөлөө үзүүлэх болно.

Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн согтуурах мансуурах донтой иргэнийг донтолтоос ангижруулах эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээнд зуучлан хамруулах, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн засал, сургалтад хамруулах, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр заасан.

Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд халамжийн сангаас олгох шүдний болон бусад протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн, мөн магадлан итгэмжлэгдсэн сувиллын үнийн хөнгөлөлтөд хамрагдахад иргэд олон бичиг баримт бүрдүүлэн, олон байгууллагаар явж үйлчилгээнд хамрагдаж байгаа нь хүнд суртал, чирэгдэл үүсгэж иргэдийг бухимдуулдаг. Нөгөө талаар халамжийн байгууллагын анхан, дунд шатны ажилтнууд амьжиргаа багатай, ажилгүй иргэдийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх ажлаас илүү дээрх хөнгөлөлтийн бичиг баримтын бүрдлийг хангах, хянах ажилд дийлэнх цагаа зарцуулдаг. Иймд эрүүл мэндийн байгууллагаас шууд хөнгөлөлт авах тогтолцоог бүрдүүлэх, халамжийн сангийн зардлыг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан.

Халамжийн байгууллага нь эмнэлгийн байгууллагын тодорхойлолт баримт бичгийг үндэслэн зөвхөн санхүүжилт олгож, хяналт хийхдээ тухайн иргэн шаардлагатай ортопед, тусгай хэрэгслээ авсан эсэх, ашиглаж байгаа эсэх, асуудал үүссэн зэргийг хянаж, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн, тусгай хэрэгсэл нийлүүлсэн байгууллагын гэрээг цуцлах арга хэмжээ авахаас хэтрэхгүй байгаа ба энэ төрлийн хэрэгслийн чанар стандарт, эдэлгээний хугацаа, тухайн хүнд хэрэгцээ шаардлагатай эсэх, бие эрхтэнд нь тохирох эсэх зэрэг мэргэжлийн чиглэлийн нарийн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна. Тиймээс цаашдаа энэ төрлийн үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагад төсөв хөрөнгийн хамт шилжүүлэх, зарим арга хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлдэг үйлчилгээтэй уялдуулахаар тусгасан.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д заасан хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдсан нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд учирсан хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ үзүүлэхээр шинээр нэмсэн.

Нийгмийн халамжийн үйлчилгээ түүний хамрах хүрээ, төрөл, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах бөгөөд зорилтот өрх, иргэнийг

чадавхжуулах, хөгжүүлэх үйлчилгээг нэмэгдүүлж мэргэжлийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэхээр тусгасан.

Нийгмийн халамжийн салбарт мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, зорилтот бүлгийн өрх, иргэнд кейс менежментийн үйлчилгээнд суурилан нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажилтны мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, нийгмийн ажилтан цаастай биш, өрх иргэн, олон нийттэй ажиллах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг дагалдуулан нийт 21 хуульд өөрчлөлт оруулахаар холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын бүх гишүүдээс санал авч, саналыг тусган боловсруулсан. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/1696 дугаар албан бичгийг мөн хүргүүлсэн.

Хуулийн төсөлд санал авахаар Монгол Улсын ерөнхий прокурорын газарт 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/990 дугаар албан бичгийг, Монгол Улсын дээд шүүхэд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/1014 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлсэн боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй тул мөн хуулийн 20.2-т заасны дагуу “тусгайлан өгөх саналгүй” гэж үзсэн болно.

Нийгмийн халамжийн нийт 40 төрлийн үйлчилгээнээс өөрчилж, нэгтгэх, зарим төрлийн үйлчилгээг шинээр нэмснээр нийт 25 төрлийн үйлчилгээтэй байхаар хуулийн төсөлд тусгасан. Нийгмийн халамжийн арга хэмжээнд давхардсан олон үйлчилгээг нэгтгэж байгаатай холбоотойгоор хамрагдах хүний тоо 229.8 мянган иргэнээр буурна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж байгаа нийт зардлыг огцом бууруулахгүйгээр, одоогийн халамжийн төсвийн хүрээнд дахин хуваарилалт хийх зарчим баримтлах тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсгэхгүй, зардал нэмэгдэхгүй юм.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийг дагалдуулан нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төслүүд батлагдсанаар нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцооны хамрах хүрээ нь оновчтой, зорилтот бүлэгт чиглэсэн, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байж, үйлчилгээ нь иргэдийн идэвхи сонголтод тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдсан, уян хатан, чанартай, хүртээмжтэй болно.

Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрлүүдийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцалснаар өрх, иргэнд олгогдож байсан тэтгэмж, үйлчилгээний давхардал арилж, халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн дэмжлэгт илүү хөрөнгө хуваарилагдах, тэдний амьжиргаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой болно.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ